

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Отгонбаяр Энхнаран

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх;							
1	Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /улсын хэмжээнд/-ын хүрээнд Сайдын тушаалаар батлагдсан ТХААГ-аас тендер шалгаруулалтад оролцсон 2 төсөлд Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байна. Үүнд: 1. Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын хичээлийн байрны жишиг нэг маягийн зураг төсөв, 500 суудал /улсын хэмжээнд, коосен хөтөлбөр/ боловсруулах	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

зөвлөх үйлчилгээний гэрээг хэрэгжүүлэхээр Боловсролын яам болон "Анга Транс" ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан болно. Тус зөвлөх үйлчилгээний гэрээнд гүйцэтгэгч зураг төсөл боловсруулж, ашиглагч талд хүлээлгэн өгөх бөгөөд захиалагч тал гэрээний төлбөрийг төлөхөөр тусгагдсан. Үндсэн захиалагч, Захиалагч, Гүйцэтгэгч гэх 3 талт гэрээг байгуулсан ба гэрээний хугацааг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгах төслийг бэлтгэн удирдлагуудаар батлуулсан болно. Тус гэрээний гүйцэтгэл 90%-тай байна. 2.

Цэцэрлэгийн барилгын холболтын зураг төсөв, 240 ор /Улаанбаатар, Хан-уул дүүрэг, Энэтхэг-монголын ерөнхий боловсролын сургуулийн цогцолбор/ боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг Боловсролын яам болон "Архитектур нэгдэл" ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан болно. Тус зөвлөх үйлчилгээний гэрээнд гүйцэтгэгч зураг төсөл боловсруулж, ашиглагч талд хүлээлгэн өгөх бөгөөд захиалагч тал гэрээний төлбөрийг төлөхөөр тусгагдсан. Үндсэн захиалагч,

					Захиалагч, Гүйцэтгэгч гэх 3 талт гэрээг байгуулсан ба гэрээний хугацааг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хүртэл сунгах төслийг бэлтгэн удирдлагуудаар батлуулсан болно. Тус гэрээний гүйцэтгэл 90%-тай байна. Дээрх гэрээнүүдтэй холбоотой гэрээний төсөл болон гэрээнд оруулах өөрчлөлт, сунгалтууд болон холбогдох бусад албан бичгүүд зэргийг боловсруулан удирдлагаар хянуулан албажуулж гэрээтэй холбогдох зарим ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.		
2	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих гадагшаа чиглэсэн дараах албан бичгийн төсөл боловсруулж хүргүүлсэн. Үүнд: -Хуулийн төсөл-3 /Гэр бүлийн хөгжлийг дэмжих" тухай анхдагч хууль, Гэр бүлийн тухай хууль, "Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль/ -Засгийн газрын тогтоол-8 /1.Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах радио, телевизийн тоог тогтоох тухай 2.Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай 3.Хөгжлийн	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				<p>бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 4.Хилийн зурвастай давхцалтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулах эрх олгох тухай 5. Төсвийн байгууллагыг өөрчлөн байгуулах тухай "Сэргээн засах, үйлчилгээний үндэсний төв"-ийн дүрэм 6.Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах тухай 7. Төсвийн байгууллагыг өөрчлөн байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл 8. Төсвийн байгууллагыг өөрчлөн зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах тухай" тогтоолын төсөлтэй - Хамтын хэлэлцээр-1 /Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоотой байгуулах 2026-2028 оны хамтын хэлэлцээрийн төсөл/ Эдгээр гадагш чиглэсэн албан бичигт хууль зүйн үндэслэлийг хангуулан хариу албан бичгийн төслийг боловсруулж дээд шатны удирдлагуудаар хянуулан албажуулж хариуг хүргүүлсэн. Дотоод бичгийн тухайд бусад</p>	
--	--	--	--	---	--

					газар хэлтсүүдээс ирсэн хуулийн төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл, гэрээ зэрэгт мөн адил хууль зүйн үндэслэлийг судалж тухай бүр холбогдох саналыг хүргүүлсэн байна. Мөн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн байгууллагын хэмжээнд байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих гадагшаа чиглэсэн албан бичгийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох дүрэм, журамд нийцүүлэн ажиллаж байна.		
3	Монгол Улсын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яам, сайд, Төрийн нарийн бичгийн даргаас олгосон итгэмжлэлийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон: Алтай трест ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох иргэний хэрэгт /2025 оны 11 дүгээр сард нэхэмжлэл ирсэн/ яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. Концессын гэрээ болон концессын гэрээний хүрээнд үйлдэгдсэн бусад баримт бичгүүдэд валютын ханшийн зөрүүг төлөх хугацааг заагаагүй мөн валютын ханшийн зөрүүнд алданги тооцохоор Концессын гэрээнд заагаагүй зэрэг үндэслэлээр хариу тайлбарыг	10-р сар, 11-р сар, 12-р сар	98%

					хамтран боловсруулан шүүхэд хүргүүлсэн болно. /Одоогийн байдлаар тус хэргийн шүүх хурлын тов тодорхойгүй байна./ Бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгжийн холбогдох албан хаагчдад дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллаж байна.		
4	Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангана.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. /100 хувь	2025 оны жилийн эцсийн байдлаар яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг боловсруулж, хянаж, нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн болно: - "Салбарын хяналтын өнөөгийн байдал ба цаашдын чиг хандлага" хэлэлцүүлгийн хүрээнд "Болор катеринг" ХХК-тай үйлчилгээ үзүүлэх гэрээг хамтран боловсруулан, удирдлагаар батлуулсан болно. -Байгууллагын албан хаагчдыг тухай бүр шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр ханган ажилласан. Яамны зохион байгуулалтын бусад бүтцийн нэгжүүдээс боловсруулсан үйлчилгээ үзүүлэх гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ зэргийг хянаж, боловсруулахад туслалцаа үзүүлсэн. -Мөн ТЗУГ-ын	10-р сар, 11-р сар, 12-р сар	96%

					долоо хоног бүрийн тайлан болон хурлын тэмдэглэл зэргийг хөтлөн архивийн нэгж үүсгэсэн.		
5	Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангана.	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар: 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт буюу ЭЗХЯ-ны УИХ, Ерөнхийлөгч, ҮАБЗ болон Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд судалгаа хийж, дүгнэлт ирүүлэх ажлын хүрээнд ХЭЗХ-ийн чиг үүрэгт хамаарах 11 тогтоол шийдвэрийн судалгааг ТЗУГ-т хүргүүлсэн болно. 2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас Бүсийн зөвлөлийн дарга болон зарим аймгийн Засаг дарга нараас гаргасан саналын дагуу аймаг, орон нутагт тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөний 36 дахь хэсэгт "Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг сэргээх, дахин байгуулах боломжийг судалж, санал боловсруулах" асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яаманд даалгасан. Энэ хүрээнд тухайн асуудлаар холбогдох судалгаа мэдээллийг хийсэн.	10-р сар, 11-р сар, 12-р сар	98%

					Үүнтэй холбогдуулаад "Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн хүрээнд гүйцэтгэсэн судалгаануудыг уншиж тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар судалж тайлан бичсэн болно. 3. Мөн түүнчлэн яамнаас боловсруулсан бусад хуулийн төслүүдэд тухай бүр хууль, эрх зүйн дүгнэлт хийж, санал хүргүүлж байсан болно.	
--	--	--	--	--	---	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан ажлын чиглэлээр мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн байх	Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх зорилгоор сургалтад	Сургалтад хамрагдсан байна.	Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн түвшинг дээшлүүлсэн байх	2025 оны жилийн эцсийн байдлаар дараах хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ахисан түвшин дээшлүүлэх сургалт, семинарт оролцсон болно: 1. "Тинк Про Солюшн" ХХК-ны Power BI & Excel+Ai ашиглан бодит өгөгдөл дээр дата анализ	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

		хамрагдах		./100 хувь/	хийх практик сургалтанд 2025.11.15-16-ны өдрүүдэд амжилттай суралцсан болно. Гэрчилгээний дугаар: -MS Power Vi+Ai -202503406 -MS Excel Vi+Ai -202503406 2. АТГ-аас 2025.11.27-ны өдөр зохион байгуулсан "Эмэгтэй манлайлагчдын хамтын ажиллагааны уулзалт-Авлигын эсрэг эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон болно. Хавсралт: 2 файл		
2	Хариуцсан ажлын хүрээнд хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон байх	Хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон байх	-	Хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон байх. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар дараах хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон болно: 1. ЭЗХЯ-д шинээр орсон албан хаагчдад зориулсан чиглүүлэх сургалтад 2025.10.03-ны өдөр идэвхтэй хамрагдсан. 2. Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газраас 2025.10.24-ны өдөр зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан. 3. Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газраас 2025.10.31-ний зохион байгуулсан "Healthy is the new cool!" зөв хооллолт, хүнсний шим тэжээлийн талаарх мэдээллийн цагт хамрагдсан. 4. Төрийн захиргааны удирдлагын газраас 2025.11.07-ны өдөр зохион байгуулсан "Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				<p>хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж" сэдвээр зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан. 5. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газраас 2025.11.14-ний өдөр зохион байгуулсан "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх" сэдвээр тус яамны ахмад, Сангийн сайд асан Ч.Улаан мэдээлэллийн цагт хамрагдсан. 6. Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсээс 2025.11.17-ны өдөр зохион байгуулсан Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилтийн ач холбогдлыг бодит жишээгээр хамтдаа хэлэлцэх өглөөний уулзалтад хамрагдсан. 7. "Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах" сэдвээр хэлэлцүүлэгт 2025.11.28-ны өдөр тус тус идэвхтэй хамрагдсан байна.</p>	
--	--	--	--	--	--

ХЯНАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дашням Ариунбилэг /...../

Огноо: 2025. 12. 15.

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Отгонбаяр Энхнаран /...../

Огноо: 2025. 12. 15.

